



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/120

Эрдэнэт

Улсын онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а”, 29.1.5 “в”, 29.1.6 “л”, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1, Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 27, 45 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2021 оны 07, 08 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хот (голомттой бүс)-оос Орхон аймагт ирэх иргэдийн зорчих хөдөлгөөн ихсэж, орон нутагт хяналт тавих, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулахад эрсдэл үүсэж байгаа тул 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 28-ны өдрийг дуустал хугацаанд хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээг зогсоож, Улсын болон Нийслэлийн Онцгой комиссоос зөвшөөрсөн тохиолдолд Улаанбаатар хотоос Орхон аймгийн иргэдийг хүлээн авах болон Орхон аймгаас гарах хүсэлт гаргасан бусад аймгийн иргэдийг хувийн болон албаны тээврийн хэрэгслээр зорчуулахаар зохион байгуулалт хийж ажиллахыг Шуурхай штаб (Г.Ганбаатар)-т үүрэг болгосугай.


2. Аймгийн хэмжээнд коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор олон нийтийг хамарсан жагсаал цуглаан, урлагийн тоглолт, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахыг 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 03 дугаар сарын 28-ны өдрийг дуустал хугацаанд хориглосугай.

3. Орхон аймаг, Эрдэнэт хотод орж, гарч, дамжин өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тавих хяналт, ажлын зохион байгуулалтыг сайжруулж, албан ёсны хяналтын постоор орж ирээгүй зөрчил гаргасан тээврийн хэрэгслийг журамлах, жолооч, зорчигчдод холбогдох хариуцлага тооцох, тусгаарлах ажлыг зохион байгуулж

ажиллахыг Онцгой байдлын газар (Г.Ганбаатар), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Тагнуулын газар (М.Очирбат), Эрүүл мэндийн газар (Д.Сүхээ), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Бат-Өлзий), Мал эмнэлгийн газар (П.Эрдэнэжаргал), Авто тээврийн төв (Г.Ядмаа), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр) нарт даалгасугай.

4. Энэхүү захирамжийг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Онцгой байдлын газар (Г.Ганбаатар), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо), Авто тээврийн төв (Г.Ядмаа), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр) нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүй дэмжлэгээр ханган, тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч А.Түвшинжаргал, аймгийн Засаг даргын орлогч М.Түмэнжаргал, Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Ганбаатар нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  С.БАТЖАРГАЛ